



**“Зүрхний ишеми ба шигдээс өвчний тусламж үйлчилгээг сайжруулах
чиглэлээр сургалт зохион байгуулах” үйлчилгээ авах ажлын даалгавар**

Ажлын даалгаврын нэр	“Зүрхний ишеми ба шигдээс өвчний тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулах” үйлчилгээ үзүүлэх
Үйлчилгээний нэр	Мэргэжлийн сургалт зохион байгуулах
Гэрээний төрөл	Сургалт зохион байгуулах үйлчилгээ
Хэлний мэдлэг	Монгол
Гэрээний хугацаа	2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 10 сарын 30-ний өдрийг дуустал

ҮНДЭСЛЭЛ

Сүүлийн жилүүдэд зүрх судасны өвчлөл нь Монгол Улсад нийт нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг хэвээр байна. Тухайлбал, артерийн даралт ихсэх, зүрхний шигдээс, зүрхний хэм алдагдал, зүрхний цочмог болон архаг эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний хүртээмж, чанар нь бүсийн болон орон нутгийн түвшинд харилцан адилгүй, эмнэлзүйн менежмент хангалтгүй байсаар байна.

Монгол Улсын Засгийн газар болон Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хооронд байгуулсан буцалтгүй тусламжаар шат дараатай хэрэгжүүлж буй төслийн гэрээний хүрээнд зүрх судасны өвчлөлийг бууруулах, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Энэхүү хамтын ажиллагаа нь зүрх судасны тусламж, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, ялангуяа анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэж байгаа юм.

Анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад зүрхний хэмийн эмгэгийг оношлох, ялган оношлох, анхан шатны тусламжийг шуурхай, зөв зохион байгуулах мэдлэг, ур чадвар дутагдалтай хэвээр байгаа нь өвчтөнд хүрэх тусламж үйлчилгээний үр дүнг бууруулах шалтгаан болж байна.

Иймд зүрхний хэмийн эмгэгийн талаарх шинэчлэгдсэн оношилгоо, эмчилгээний хандлага, удирдамжийн талаарх мэдлэгийг эмч, мэргэжилтнүүдэд хүргэх, практикт хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тус сургалтыг зохион байгуулах нь зүйтэй юм. Энэ нь зүрхний хэм судлалын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, өвчтөнд үзүүлэх тусламжийг илүү үр дүнтэй, аюулгүй болгоход чухал ач холбогдолтой.

СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад зүрх судасны өвчин, тэр дундаа зүрхний ишеми ба шигдээс өвчний нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг бөгөөд нийгмийн эрүүл мэндэд тулгамдсан асуудал болсоор байна. Улсын хэмжээнд 2024 оны байдлаар нийт нас баралтын 36 хувийг¹ зүрх судасны өвчлөл эзэлж байгаа бөгөөд зонхилж буй зүрх судасны өвчлөлийн нэг нь зүрхний ишеми ба шигдээс өвчин юм.

Зүрхний ишеми ба шигдээс өвчин нь оношлох, эмчлэхэд нарийн мэргэшил, тоног төхөөрөмж шаарддаг ч анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад хүний нөөцийн мэдлэг, чадвар, техник технологийн дутмаг байдал нь оношилгоо, эмчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Үүнээс улбаалан оношилгоо алдагдах, буруу онош тавих, цаг алдах зэрэг асуудлууд гарч, улмаар гуравдагч шатлал руу шилжүүлэлт ихэсч, эмнэлгийн ачаалал нэмэгддэг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд зүрхний ишеми ба шигдээс өвчинтэй холбоотой тусламж үйлчилгээг анхан шатнаас нь чанаржуулах, эмч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймд орчин үеийн оношилгоо, эмчилгээний арга барилыг практикт нэвтрүүлэх, стандарт, удирдамжид суурилсан сургалтаар дамжуулан эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах нь энэхүү сургалтын зорилго болно.

АЖЛЫН ЗОРИЛГО

Анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн зүрхний ишеми ба шигдээс өвчний талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар зүрхний ишеми ба шигдээс өвчний тусламж, үйлчилгээг сайжруулах, өвчтөнд үзүүлэх тусламжийг илүү үр дүнтэй, хүртээмжтэй, аюулгүй болгох орчныг бүрдүүлэхэд энэ ажлын зорилго оршино.

ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮР ДҮН

Дараах багц ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Сургалтын хэрэгцээ, шаардлагын үнэлгээ хийх
 - Анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын зүрхний ишеми ба шигдээс өвчний тусламж үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, сургалтын агуулга боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах.
 - Үр дүн: Сургалтын үндэслэл бүхий хэрэгцээ, шаардлагын тайлан гарсан байна.
2. Сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах
 - Зүрхний ишеми ба шигдээс өвчний талаарх онолын болон практик мэдлэгийг хамарсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж батлуулах.
 - Үр дүн: Стандартад нийцсэн, мэргэжлийн сургалтын хөтөлбөр, гарын авлагатай болсон байна.
3. Сургалтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх
 - Сургалтыг орон нутагт болон төвлөрсөн хэлбэрээр 2 удаа зохион байгуулж, оролцогч эмч, мэргэжилтнүүдэд хичээл заах.
 - Үр дүн: Сургалтад хамрагдсан оролцогчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн, сургалтын тайлан, үнэлгээний үр дүн гарсан байна.
4. Сургалтын дараах үнэлгээ, зөвлөмж боловсруулах
 - Сургалтын үр нөлөөг үнэлж, цаашдын тасралтгүй сургалт, чадавх бэхжүүлэх ажлуудад зориулсан зөвлөмж боловсруулах.
 - Үр дүн: Үр нөлөөний тайлан, хэрэгжүүлэх зөвлөмж бүхий баримт бичигтэй болсон байна.

¹ 1313 mn - Статистик мэдээллийн сан

ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 10 сарын 30-ны өдрийг хүртэл.

МОНИТОРИНГ, ЯВЦЫН ХЯНАЛТ, ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Захиалагч ажлын явцад хяналт тавихад зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь эхний сургалт зохион байгуулсны дараа **явцын тайлан** боловсруулан захиалагч талд хүргүүлнэ. Явцын тайлан нь гүйцэтгэлийн явц, тулгарч буй хүндрэл, шийдвэрлэсэн арга хэмжээ, дараагийн шатны төлөвлөгөө зэргийг тусгасан байна.

Зөвлөх үйлчилгээний **эцсийн нэгдсэн тайланг** Монгол хэл дээр боловсруулж, зөвлөх үйлчилгээ дууссаны дараа хүлээлгэн өгнө. Тайланд дараах агуулга заавал багтсан байна:

- Ажлын зорилго, үндэслэл, аргачлалын товч тайлбар
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд, сургалтын агуулга, оролцогчдын мэдээлэл
- Хүрсэн үр дүн, үнэлгээний үр дүн
- Сургалтын үр нөлөөний дүгнэлт ба зөвлөмж
- Хавсралт баримт бичгүүд (материалууд, оролцогчдын бүртгэл, үнэлгээний хуудас гэх мэт)

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Захиалагч нь үйлчилгээ үзүүлэх байгууллагын гүйцэтгэсэн ажлыг дүгнэх зорилгоор гэрээний биелэлтэд хяналт тавьж, үнэлгээ хийнэ. Гэрээний биелэлтийг дараах оролцогч талууд хамтран үнэлж дүгнэнэ:

- **Нэг талаас:** УГТЭ-ийн Зүрх судасны үндэсний төв (захиалагч тал)
- **Нөгөө талаас:** Үйлчилгээ үзүүлэгч байгууллага

Үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

- Гүйцэтгэсэн ажлын чанар, тайлангийн агуулга, боловсруулалтын түвшин
- Гэрээт хугацаанд гүйцэтгэлийг хийсэн эсэх
- Ажлын даалгаврын шаардлагын биелэлт
- Сургалт, судалгааны үйл ажиллагааны үр нөлөө
- Харилцаа, хамтын ажиллагаа, мэргэжлийн ёс зүй

ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА

Сургалтын үйлчилгээ үзүүлэх байгууллага дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Ижил төстэй чиглэлээр (эрүүл мэнд, анагаах ухаан, сургалт, судалгаа) зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх;
- Төслийн хэрэгжилтийг хангахуйц мэргэжлийн ур чадвартай сургах баг бүрдүүлсэн байх;
- Доорх шаардлагыг хангасан мэргэжлийн багтай байх:

Сургах багийн ахлагч

Боловсрол: Анагаах ухааны магистр ба түүнээс дээш зэрэгтэй;

Туршлага: Сүүлийн 5-аас доошгүй жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай байх ба сургалт, зөвлөх үйлчилгээ, судалгааны чиглэлд ажиллаж байсан туршлагатай байх;

Ур чадвар: Баг удирдах, сургалтын хөтөлбөр боловсруулах, эрүүл мэндийн бодлого, менежменттэй холбоотой төсөл хэрэгжүүлэх ур чадвар эзэмшсэн байх.

Сургах багийн гишүүд

Боловсрол: Анагаах ухаан, сувилахуйн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;

Туршлага: Зүрх судасны өвчлөл, хэм судлал, анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай;

Ур чадвар: Сургалт зохион байгуулах, мэдээлэл боловсруулах, судалгаа хийх, багийн ажиллагаанд идэвхтэй оролцох чадвартай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Байгууллагын танилцуулга, гэрчилгээ;
- Сургах багийн ахлагч болон гишүүдийн мэдээлэл, чадавхыг харуулсан танилцуулга ба тэдний CV;
- Сургалтын хөтөлбөр ба төлөвлөгөө;
- Арга зүй, аргачлал;
- Үнийн санал;
- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан

Ур чадвар: Баг удирдах, сургалтын хөтөлбөр боловсруулах, эрүүл мэндийн бодлого, менежменттэй холбоотой төсөл хэрэгжүүлэх ур чадвар эзэмшсэн байх.

Сургах багийн гишүүд

Боловсрол: Анагаах ухаан, сувилахуйн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;

Туршлага: Зүрх судасны өвчлөл, хэм судлал, анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай;

Ур чадвар: Сургалт зохион байгуулах, мэдээлэл боловсруулах, судалгаа хийх, багийн ажиллагаанд идэвхтэй оролцох чадвартай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Байгууллагын танилцуулга, гэрчилгээ;
- Сургах багийн ахлагч болон гишүүдийн мэдээлэл, чадавхыг харуулсан танилцуулга ба тэдний CV;
- Сургалтын хөтөлбөр ба төлөвлөгөө;
- Арга зүй, аргачлал;
- Үнийн санал;
- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан